

МОНГОЛ, ВЬЕТНАМЫН ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА - ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

*Б.Гантуяа**

Монгол Улс, БНСВУ-ын хооронд дипломат харилцаа тогтоогоод 53 жил болж байна. Хоёр тал Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын анхны хэлэлцээрт 1957 оны 6 дугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зурсан, 1979 онд хоёр улсын худалдаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааг тодорхой зорилго, чиглэл, төлөвлөгөөтэй хөгжүүлэх үүднээс Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын Комисс байгуулагдаж, хоёр улсын хооронд бэхжин тогтсон улс төрийн найрсаг харилцааг худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаагаар бэхжүүлэх, хамтын ажиллагааг бүхий л салбар, түвшинд хөгжүүлэх шинэ үе эхэлсэн.

1990-ээд оны эхээр хоёр улсад өөрчлөлт, шинэчлэл өрнөж, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжин орсноор, 1990 оныг хүртэл хэвийн, тасралтгүй, урагшлан хөгжиж ирсэн хоёр талын харилцаа, ялангуяа худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа зогсонги буюу идэвхгүй байдалд орж, хөгжүүлэх боломж хязгаарлагдмал болсон. 1991 онд Монгол, Вьетнамын Засгийн газрын хооронд худалдаа, төлбөр тооцооны тухай шинэ хэлэлцээр байгуулагдаж, 1991 оны 1-р сарын 1-нээс эхлэн хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүх төрлийн төлбөр, тооцоог олон улсын худалдааны нөхцөл практик болон орон тус бүрийн валютын дүрэм журмын дагуу тухайн бараа, үйлчилгээг дэлхийн зах зээлийн үнээр чөлөөтэй хөрвөдөг валютаар гүйцэтгэж эхэлсэн.

Өмнөх хуралдаанаас хойш 8 жил завсарласан Монгол-Вьетнамын Засгийн газар хоорондын Комиссын VIII хуралдаан нь 1996 оны 5 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж, 90-ээд оны эхэн үеэр зогсонги байдалд орсон хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа, гадаад худалдааны цар хэмжээ эрс буурч, үндсэндээ байхгүй болсон гадаад худалдааг зах зээлийн шинэ нөхцөлд хөгжүүлэх талаар санал бодлоо солилцож, төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэхэд голчлон хандуулсан. 1999 оны 12 дугаар сард хоёр улсын хооронд худалдааны түншүүдийг хөгжүүлэн дэмжих, шинэ зуунд харилцан ашигтай хамтын ажиллагаанд түлхэц өгөх зорилгоор Монгол-Вьетнамын Засгийн газар хоорондын Комиссын IX хуралдаан

* Б.Гантуяа - магистр

хуралдаж, Худалдааны тухай хоёр улсын Засгийн газар хоорондын шинэ хэлэлцээрт гарын үсэг зурсан. Уг хэлэлцээр нь шинэ нөхцөлд үйл ажиллагаагаа явуулж байгаа хоёр улсын бизнесменүүдэд эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, худалдааны үйл ажиллагааг дэмжихэд түлхэц өгч, экспорт, импортын бүтээгдэхүүний хуваарилалтад зохицуулалт хийх, гадаад худалдаанд гаалийн татвар, хураамж ноогдуулах хувь, хэмжээг тогтоох асуудлыг хоёр улсын өнөөгийн хууль тогтоомжинд нийцүүлэн шийдвэрлэхэд тэргүүн зэргийн ач холбогдол өгсөн. Ийнхүү Монгол, Вьетнамын харилцаа шинэ шатанд гарч, харилцаа, хамтын ажиллагаа бүх салбарт үсрэнгүй хөгжих суурь тавигдсан.

Засгийн газар хоорондын Комиссын үйл ажиллагаа хэвийн, идэвхитэй явагдаж, гэрээ, хэлэлцээрүүд бодит амьдралд хэрхэн, яаж хэрэгжиж байгаа нь өнөөдөр нэн чухал байна. Монгол, Вьетнам хоёр улсын дээд хэмжээний уулзалт, Засгийн газар хоорондын Комиссын хуралдаанаар дэвшүүлж буй зорилтуудыг шинэ нөхцөл байдалд зохицуулан хэрэгжүүлэх, өмнөх хуралдааны шийдвэр, хэлэлцээрүүдийн биелэлтийг дүгнэх, салбар, субъектуудын хамтын ажиллагааны шинэ хэлбэрүүдийг бий болгох, хамтын түншлэлийг бэхжүүлэх үр ашигтай *механизмыг* бий болгох, худалдаа, хамтын ажиллагаанд оролцогчдод улам илүү таатай нөхцөл бүрдүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэж, оновчтой шийдвэр гаргах шаардлагатай. Үүний тулд хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үечилсэн мастер төлөвлөгөө, хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхэд онцгой анхаарч ажиллах ёстой.

Өнгөрсөн хугацаанд БНСВУ-д хийгдсэн төрийн болон албан ёсны айлчлалуудын үеэр Монгол Улсын төр, засгийн удирдлагууд, бизнесийн хүрээний хүмүүсийн байгуулсан гэрээ, хэлэлцээрээр хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа амжилттай хөгжиж ирсэн. Уг гэрээ, хэлэлцээрүүд эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд тулгуурласан, хоёр орны худалдаа, эдийн засгийн чадавхи, хэрэгцээ, онцлогт тохирсон, эрх зүйн үндэс бүхий худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэн хөгжүүлэхэд чиглэгдсэн. 1994 онд “Монгол, Вьетнам хоёр орны хамтын ажиллагааны Тунхаглал”, 1995 оны 5 дугаар сард “Татварыг давхардуулж ноогдуулахгүй байх, татвар төлөхөөс, зайлсхийхээс урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр”, 2000 оны 4 дүгээр сард “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”, 2002 оны 5 сард “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай шинэ гэрээ” (1961, 1979, 2000) зэрэг баримт бичгүүдэд гарын үсэг зурсан явдал хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалт, соёл, шинжлэх ухаан, техникийн салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх зарчимд тулгуурласан хууль эрх зүйн

шинэ үндэс суурийг бий болгож өгсөн төдийгүй хоёр улсын эдийн засаг, худалдааны өнөөгийн хөгжлийн хурдацыг 2010 он гэхэд хоёр дахин нэмэгдүүлэх стратегийн зорилтоо хэрэгжүүлэх урьдчилсан нөхцлийг бүрдүүлж өгчээ.

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа

Хэдийгээр хоёр талын худалдааны нийт бараа эргэлт аажмаар өсч, Монгол Вьетнамын хамтын ажиллагааны ирээдүй өөдрөг төсөөлөлтэй байгаа ч өнөөгийн бодит амьдрал дээр хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа туйлын хангалтгүй байна.

1994 онд манай хоёр орны бараа эргэлт 131.5 мянган ам.доллар болж, манай улсын гадаад худалдааны нийт эргэлтийн 0.1%, 1996 онд 0.2 хувь, 1997, 1998 онуудад 0.6%-д тус тус эзлэж Монгол, Вьетнам хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцааны идэвхжлийн нэг гол илрэл болсон. 2005 онд нийт худалдааны эргэлт 2601.3 сая ам.доллар, үүнээс импорт 2568.9 сая ам.доллар болж, манай улсын нийт импортын 0.2 хувийг эзлэж, 2006 онд 2961.6 сая ам.доллар байсан импорт, 2007 онд 5723.1 сая ам.доллар болж, 2 дахин нэмэгдсэн. 2007 онд хоёр орны худалдааны алдагдал 5.7 сая ам.доллар болж өссөн байна. БНСВУ-тай хийсэн худалдааны хэмжээг сүүлийн жилүүдээр авч үзвэл:

Монгол, Вьетнамын худалдааны бараа эргэлт

Жил	Нийт эргэлт	Экспорт	Импорт	Импортод эзлэх хувийн жин %
	мянган ам.доллар			
1991	6.7	-	6.7	0.002
1994	131.5	-	131.5	0.05
1995	253.1	1.5	251.6	0.06
1996	676.3	-	676.3	0.16
1997	2685.0	37.1	2647.9	0.56
1998	3014.6	-	3014.6	0.64
1999	1716.6	3.9	1712.7	0.33
2000	1550.9	1.5	1549.4	0.23
2001	2479.8	1.0	2478.8	0.36
2002	2047.1	23.5	2023.6	0.27
2003	1743.7	15.7	1728.0	0.22
2004	2208.3	8.2	2200.1	0.22
2005	2601.3	32.4	2568.9	0.21
2006	2970,0	8.4	2961.6	0.22
2007	5723,1	0,0	5723.1	0.26



*Эх уулавч: Монгол Улсын Статистикийн Төв Газар,
Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газар*

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа бол хоёр урсгалтай хөдөлгөөн билээ. Монгол, Вьетнам хоёр орны хооронд хийгдэж буй гадаад худалдааны ерөнхий чиг хандлага 90-ээд оноос хойш ихэвчлэн Вьетнамын талаас давамгайлж, импортын эрчимтэй өсөлт цаашид ч нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь Вьетнам улс зах зээлийн өргөн боломжтой, аж ахуй эрхлэх хямд, дадлага туршлагатай, боловсролтой ажиллах хүчний арвин их нөөц нь гадаад хөрөнгө оруулалтыг өөртөө татаж, үйлдвэрлэлийн өртөг зардал бага, гарах бүтээгдэхүүний өртөг хямд байх тул Вьетнамын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ бусад улс орны зах зээл дээр хямд тусч байгаатай холбоотой. Монголд нийлүүлдэг Вьетнамын бараа бүтээгдэхүүн, Вьетнамд экспортлосон Монголын барааны бүтцийг авч үзвэл:

Монгол-Вьетнамын экспортын гол нэрийн бараа: *Оёдлын машин, түүний зуу, ширээ, нуд, таг; Цахилгаан гүйдлийн аппаратуудад тусгайлан буюу голлон хэрэглэгдэх эд анги; Төрөл бүрийн материалаар хийсэн цахилгаан тусгаарлагч; Хөнгөн тэрэг; Чиргүүл, хагас чиргүүл, өөрөө явагч биш бусад тээврийн хэрэгсэл, эд анги.*

Монгол-Вьетнамын импортын гол нэрийн бараа: *Шар буурцагны тос, Чихэр, чихрийн зүйлс, бохь, Лаазалсан ногоо, жимс, самар (цууны хучилд дарсан), Талх, амтлаг гурилан зүйлс; Үс арчлах зориулалтын бэлдмэл; Амны хөндий буюу шүдний ариун цэврийг сахих зориулалтын бэлдмэл, оо; Угаалгын бодис; Боодлын хуванцар хайрцаг, сав, таглаа; Шилэн лонх, сав, домбо, ваар, ампул.*

Монгол Улс Вьетнамаас гол төлөв хөнгөн аж үйлдвэрийн бараа, хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, үүнд цагаан будаа, хатаасан жимс зэрэг дундаас доод түвшний өдөр тутмын хэрэглээний барааг импортлоно.

Ер нь хоёр орны зах зээлд харилцан бараа нийлүүлэх, экспорт, импортын барааны хуваарилалтад зохицуулалт хийх, нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах талаар хийсэн нарийн судалгаа одоогоор байхгүй. Өнөөдөр Монгол, Вьетнам хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааны агуулга, шинж чанар, зарчимд өөрчлөлт оруулж, харилцан нийлүүлэх экспортын гол бараа бүтээгдэхүүний бүтэц болон хэмжээ тоог улам өргөжүүлэх боломжтой. Тухайлбал, **Монголоос экспортлож болох гол нэрийн бараа**: *Малын яс (дахин боловсруултанд), төрөл бүрийн давсалсан арьс, хонины ноос, савхин эдлэл, ноос ноолууран бараа бүтээгдэхүүн, мод, нарс, хунс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, уунд, хонь, үхрийн мах, хуурай суу, суун бүтээгдэхүүн* зэргийг санал болгож Вьетнамын зах зээлд оруулах боломжтой.

Вьетнамын талаас импортлож болох гол нэрийн бараа:

Хунс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээс: цагаан будаа, элсэн чихэр, гахай, тахианы мах, гадил жимс болон бусад төрлийн хатаасан жимс, давс, өргөст хэмх, далайн гаралтай ургамал амьтны хунс тэжээл, самар, самартай чихэр, пиво, ургамалын тос, кофе, ногоон цай, халуун ногоо; Вьетнамд үйлдвэрлэгдсэн ХАА, тариалангийн ажилд хэрэглэх бага оврын техник, гэр ахуйн цахилгаан болон электрон бараа, компьютер, компьютерийн эд анги; Сулжмэл болон бөс даавуун хувцас, гутал, торго дурдан; Гар урлалын бараа; Эм, эмийн бэлдмэл; Барилгын материал; Пластмассан бараа бүтээгдэхүүн зэргийг санал болгож Монголын зах зээлд оруулах боломжтой.

Хэдийгээр Монгол Улс болон Вьетнам улсын Засгийн газар худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхижүүлэх хөгжлийн бодлого, гэрээ хэлэлцээрийн асуудал зохицуулах чиглэлээр багагүй хүчин чармайлт гарган ажиллаж, тодорхой хэмжээний ахиц, дэвшилтэнд хүрсэн боловч өөрчлөгдөж байгаа өнөөгийн нөхцөлд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлогыг нэгтгэн зангидах систем үгүй, оролцогч талуудын ажлын уялдаа муу, хувь хүмүүс, компаниудын санаачлагаар голдуу явагдаж байна. Өнөөдөр Монгол, Вьетнам хоёр улсын бизнес эрхлэгчид өөрийн орны эрэлт хэрэгцээ, эдийн засгийн өсөлт, бүтэцтэй уяалдуулан хамтарсан буюу 100 хувийн хөрөнгө оруулалттай компани байгуулан ажиллаж байна. Монголд 10 гаруй жил үйл ажиллагаагаа явуулж буй Вьетнамын хөрөнгө оруулалттай “Баруун хоршоо”, “VIMOS”, “LPL” зэрэг компаниуд нь Вьетнамын хүнсний бүх төрлийн бүтээгдэхүүнийг оруулан Монголын зах зээл дээр борлуулж, автомашины засвар, фотостудийн үйлчилгээ болон бусад үйл ажиллагаа эрхэлдэг.

Цаашид оновчтой бодлого, уян хатан үйл ажиллагаа, аль аль талын боломж, сонирхол зэргийг хөгжлийн бодлогодоо тусгаж,

шинэлэг санаа, арга барилаар идэвхтэй ажиллаж, системчлэн хөгжүүлж чадвал улсын эдийн засагт илүү үр ашигтай, мөн хоёр орны бүх талын харилцаа, хамтын ажиллагаа өмнөх жилүүдээс эрчимтэй хөгжих болно. Жишээлбэл, хоёр орны хооронд тодорхой нэр төрлийн бараагаар чөлөөт худалдааны тогтолцоо бий болгох асуудлыг судлах; БНХАУ-ын нутгаар тээвэрлэж байгаа монголын экспорт, импортын болон транзит барааны төмөр замын тээврийн тарифыг бууруулах талаар яриа хэлэлцээг цаашид үргэлжлүүлэх; хүнс, ХАА-н салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор хөдөөгийн хүн амыг хямд эрчим хүчээр хангах, хүнс, хөдөө аж ахуйн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах, ядуурлыг бууруулах үүднээс өрхийн аж ахуйг фермерийн аж ахуй болгон хөгжүүлэх зэрэг Вьетнамын туршлагыг судлах ажлыг зохион байгуулах; Монгол орны байгаль орчин муудаж байгаатай холбон агаарын бохирдол, хог хаягдлын зөв менежмент, байгаль орчны хамгаалалт, эко-туризм, дэлхийн цаг уурын дулааралтай тэмцэх зэрэг салбарт хамтран ажиллах боломжтой.

Монгол Улс дахь Вьетнамын хөрөнгө оруулалтын байдал

Вьетнамын бизнес эрхлэгчидийн эрэлт хэрэгцээний хувьд, түүхий эдийн арвин нөөцтэй, хоёр том гүрний хооронд байршилтай, бизнесийн таатай орчинтой, техник технологи, ноу-хау, шууд хөрөнгө оруулалт, бизнесийн туршлага, менежмент ихээхэн хэрэгцээ шаардлагатай Монгол Улсад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн боломжтой, үүнд түүхий эд, нөөц баялагт тулгуурласан нэмүү өртөг шингээсэн жижиг дунд хэмжээний боловсруулах үйлдвэрүүдийг барьж байгуулбал ашигтай байна. Өнөөдөр Монгол, Вьетнам хоёр улсын хөрөнгө оруулалт, худалдаа, бизнесийн хамтын ажиллагаа урьдынхаас илүү олон хэлбэрээр явагдаж, хөгжлийн ерөнхий чиг хандлага нь хамрах хэмжээ, далайцаараа цаашид ч өргөжих нь дамжиггүй. Монгол, Вьетнам хоёр улс хоорондын хөрөнгө оруулалтыг үр ашигтай болгох, хөрөнгө оруулалтыг дэмжих оновчтой бодлогыг боловсруулах, эрх зүйн зохистой орчинг улам боловсронгуй болгож хөгжүүлбэл үр шимээ бага багаар өгнө.

Вьетнамын хөрөнгө оруулагчид 90-ээд оны сүүлээс Монголд хөрөнгө оруулалт хийж эхлэсэн бөгөөд үйлдвэрлэл, үйлчилгээний олон салбарыг сонирхон хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсээр байна. Вьетнамын хувийн хэвшлийн зүгээс уул уурхай, барилга, эрчим хүч, хөнгөн үйлдвэрлэл, хөдөө аж ахуй (мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэл), аялал жуулчлал (аялал жуулчлал хөгжүүлэх, зочид буудал, жуулчны бааз байгуулах болон түүний менежментийг дээшлүүлэх) зэрэг салбаруудад хөрөнгө оруулалт хийж, хамтарч ажиллах сонирхол нэмэгдэж байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Үүний нэг тод

жишээ бол, БНСВУ-аас үзүүлэх тусламжийн хүрээнд 1990 онд Вьетнамын хөрөнгө оруулалттай Увс аймгийн Өндөрхангай сумын Чигж гол дээр 200 квт-ын хүчин чадалтай УЛС, 2006 онд Баян-Өлгий аймгийн Булган сумд 200 квт-ын хүчин чадалтай усан цахилган станц барьж байгуулсан. Вьетнамын газрын тосны “Петровьетнам” улсын үйлдвэр, АНУ-ын “SOKO” компанитай хамтран Монголд газрын тосны хайгуул, олборлолтод хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллах тухай 3 талын гэрээнд 1999 оны 11 сард гарын үсэг зурсан. Уг гэрээнд “SOKO” компани Монгол Улсад газрын тосны үйл ажиллагаа явуулж буй өөрийн салбар “SOKO Тамсаг Монголиа” компанийн хувьцааны 5 хувийг “Петровьетнам” компанид шилжүүлэх талаар тохиролцсон байна.

2000 онд Вьетнам улсаас нийт 161.7 мянган ам.долларын хөрөнгө оруулалттай 7 компани бүртгэгдсэн бол 2003 онд компаний тоо 13-т хүрч, хөрөнгө оруулалт 113 мянган ам.доллар болон өсчээ. 1991-2003 оны хооронд Вьетнамын тал нийтдээ 376 мянган ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд Монгол дахь Вьетнамын компаниудын хөрөнгө оруулалтыг салбар тус бүрээр авч үзвэл, эрүүл мэнд, гоо сайханы үйлчилгээний салбарт 50 мянган ам.доллар, хөдөө аж ахуйн салбар 45 мянган ам.доллар, худалдаа, нийтийн хоолны салбарт 6 мянган ам.доллар, барилга, барилгын материалын үйлдвэрлэлд 20, нийтийн ахуйн үйлчилгээнд 18 мянган ам.доллар, тээвэр 10 мянган ам.доллар, бусад салбарт 227 мянган ам.долларын хөрөнгө тус тус оруулсан байна. 2007 онд БНСВУ-аас Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ өнгөрсөн 10 гаруй жилийнхээс 2 дахин өссөн байна.

Монголд хөрөнгө оруулалт хийсэн Вьетнамын компаний тоо /мянган ам.доллар/

Салбар	Нийт тоо	1991	1996	1999	2000	2001	2002	2003
Эрүүл мэнд, гоо сайханы үйлчилгээ	50	50						
Хөдөө аж ахуй	45				30	8		8
Барилга, барилгын материалын үйлдвэрлэл	20		15				5	
Нийтийн ахуйн үйлчилгээ	18						11	7
Тээвэр	10							10
Худалдаа, нийтийн хоол	6						6	
Бусад	227			60	5	35	37	89
Нийт тоо	376	50	15	60	35	43	60	113

Эх уусвэр: Монгол Улсын Сангийн Яам

Хэдийгээр БНСВУ манай улсын хөрөнгө оруулалтын харьцангуй шинэ түнш боловч Вьетнамаас хийгдэж буй хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд тогтвортой өсөн нэмэгдэж байгаа нь Монголд хөрөнгө оруулах боломж, бизнесийн үйл ажиллагаа хийх муугүй нөхцөл байгаа, хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа цаашид ч өргөжин тэлэх боломжтойг харуулж байна.

Вьетнам улсад хөрөнгө оруулах таатай нөхцлүүд

Өнөөдөр Вьетнамд худалдаа эрхлэх, хөрөнгө оруулах эерэг нөхцөл нэгэнт бий болсон. Вьетнам нь Монгол орны хувьд Зүүн Өмнөд Ази болон Ази Номхон далайн орнуудын зах зээлтэй холбох хамгийн дөт зам. Монгол, Вьетнам хоёр орны харилцан ашигтай, найрамдалт харилцаа Зүүн Өмнөд Ази болон Ази Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хөгжилд манай орны гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийг нэмэгдүүлэхэд туслана.

Улс төрийн хувьд, Вьетнам улсад нийгэм, улс төрийн тогтвортой байдал, шашин, үндэстэн хоорондын зөрчил, зэвсэгт мөргөлдөөн зэрэг байхгүй, хууль, эрх зүйн таатай орчин нэгэнт бүрдсэн. Улс төр, эдийн засгийн эрсдлийн консалтинг байгууллагаас (PERC - Political and Economic Risk Consultancy, Ltd.) хийсэн судалгаагаар, Вьетнам улс гадны сөрөг нөлөөнд үл автагдах Азийн улс орнуудын эгнээнд орж, эрсдлийн оноо 3.44 байна. (эрсдлийн үнэлгээг 1-10 хүртэл оноогоор авчээ). Энэ нь Вьетнамд худалдаа эрхлэх, хөрөнгө оруулж, бизнес эрхлэх муугүй нөхцөл байгааг нотолж байна.

Эдийн засгийн хувьд, Вьетнам улс нөөц бололцоо ихтэй, 85 сая хүн амтай, зах зээлийн худалдан авах чадвар өдрөөс өдөрт нэмэгдэж, өөрчлөлт шинэчлэлийг эрчимтэй өрнүүлж буй Вьетнам улс хөгжлийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглаагүй, харьцангуй залуу (25-35 насны), оюунлаг чадвар ихтэй, боловсролтой, өртөг багатай ажиллах хүчний нөөцтэй, хөрсөн доорхи баялаг ихтэй, аялан зорчих, байгаль, газар зүй, түүх, соёл иргэншлийн тааламжтай болон өвөрмөц газар нутагтай зэрэг эерэг нөхцөл, хүчин зүйлүүд Монголын бизнес эрхлэгчид өөрсдийн бараа бүтээгдэхүүнээ Вьетнам улсад экспортлох, худалдаа наймаагаа урт удаан хугацаагаар тогтвортой эрхлэх, аюулгүй, эрсдэл багатай нөхцөлд хөрөнгө оруулах боломжтойг баталж байна.

Хоёр орны худалдаа, бизнесийн хөгжилд учирч буй бэрхшээлүүд

Монгол, Вьетнам хоёр орны худалдаа, эдийн засаг, бизнесийн хөгжилд учирч буй бэрхшээлийг дараахи байдлаар тодорхойлно.

Монгол, Вьетнамын худалдааны эргэлтийн цаашдын өсөлтийг сааруулах нэг тулгамдсан хүчин зүйл бол транзит тээврийн асуудал.

Монголын гадаад худалдаанд Зүүн Өмнөд Азийн орнуудтай хийх худалдаа томоохон байр суурь эзэлдэг бөгөөд худалдааны тээврийн дийлэнх хувь нь БНХАУ-ын нутгаар дамжин өнгөрдөг. Хятадын нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэх Монголын ачаа тээвэрлэлтийн өртөг зардал Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх тээврийн тарифаас даруй 1.4-2.0 дахин өндөр байдаг. Хамгийн ойр гарам болох Хятадын Тяньжин боомт гэхэд л 1134 км зайтай. Монгол, Вьетнамын худалдааны эргэлт өнөөдөр далайн тээврээр, Хятадын Тяньжин, Гонконг зэрэг боомтоор дамжин хэрэгжиж байна. Далайд гарцгүй манай орны хувьд дэд бүтцийн салбарын сул хөгжил, импортын бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт, татан авалтад учирч буй төмөр зам, авто тээврийн шилжүүлэн ачилт, буулгалтын хүндрэл, манайхаас нийлүүлж буй бараа, бүтээгдэхүүний ачаа тээвэрлэлтийн өндөр өртөг зардал, хугацаа бусад орныхтой харьцуулахад удаан байдаг зэрэг худалдааны тээвэрлэлтийн асуудал хүнд бэрхшээлийн нэгд тооцогдох бөгөөд үүнийг хөнгөвчлөх асуудал нэн тэргүүний болоод байна. Тээврийн төлбөрийг бууруулж, дотоодын тарифаас дутуугүй хөнгөлөлт эдлэх, тээвэрлэлтэд учирч буй саад бэрхшээлийг зохицуулах нь Монгол, Вьетнам хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэхэд түлхэц болох чухал ач холбогдолтой.

2001 оны 10 сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Монгол-Вьетнамын Засгийн газар хоорондын худалдаа, эдийн засаг, ШУТ-ийн хамтын ажиллагааны Комиссын X хуралдаанаар хоёр улсын хооронд худалдаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд учирч буй бэрхшээлтэй хэд хэдэн асуудлуудыг авч хэлэлцэж, үүнд Монгол, Вьетнамын хооронд бараа тээвэрлэлтийг Хятад улсын төмөр замаар дамжин өнгөрүүлэх тухай хэлэлцээрт талууд гарын үсэг зурахаар тохиролцсон. 2002 оны 2 сард, Монгол, Вьетнамын хооронд Хятадын нутгаар дамжин олон улсын төмөр замаар ачаа тээвэрлэх тухай Монгол Улс, БНСВУ, БНХАУ-ын хоорондын 3 талын хамтын ажиллагааны хэлэлцээр, 2004 оны 5 дугаар сард Монгол, Вьетнам хоёр улсын төмөр замын салбарт хамтран ажиллах гэрээнд тус тус гарын үсэг зурсан. Уг гэрээнд Вьетнам, Хятадын хилээр гарах вьетнам барааны төмөр замын тээврийн зардлыг 50%-иар хямдруулах талаар заасан байдаг.

Гадаад худалдааны төлбөр тооцоог гүйцэтгэх асуудал. Манай импорт эрхэлдэг аж ахуйн нэгжүүд төлбөр тооцоогоо аль болох түргэн шуурхай, найдвартайгаар банкаар дамжуулж хийх нь маш чухал. Комиссын X хуралдааны үеэр Монгол, Вьетнамын Төв Банкууд төлөөлөгчийн газар байгуулах, хоёр орны бизнес эрхлэгчдэд гадаад худалдааны төлбөр тооцоог хэрэгжүүлэхэд худалдааны банкуудад дэмжлэг үзүүлэхээр тохиролцож, Монгол, Вьетнам хоёр улсын банкны системийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан ашигтай, таатай нөхцлийг

бүрдүүлэх зорилгоор Банкны салбарт хамтран ажиллах тухай хамтарсан Тунхаглалд гарын үсэг зурсан. 2002 оны 10 сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Олон улсын Хөрөнгө оруулалтын Банк (МВ), Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны Банк (МВЕС) хоорондын жил бүрийн хуралдаанаар Монгол, Вьетнам хоёр улсын Төв Банкны удирдлагууд Төв Банк хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх тодорхой арга хэмжээний талаар харилцан санал солилцсон байна.

Өнөөдрийн байдлаар, Вьетнам улсын “VIETCOM” банк нь Монгол Улсын Худалдаа, Хөгжлийн Банк, “Голомт”, “Зоос” зэрэг 3 банктай харилцаа тогтоогоод байна. Вьетнам улсын Үйлдвэр Худалдааны Банк Монгол Улсын Худалдаа Хөгжлийн Банктай төлөөлөгчийн харилцаа тогтоосон. Хоёр орны иргэд худалдаа арилжаа хийх, хамтын ажиллагааг чанартай, үр ашигтай болгон хөгжүүлэх эрх зүйн таатай нөхцөл бүрдүүлэхийн тулд 2005 оны 1 сард Арилжааны банк хоорондын хамтын ажиллагааны санамж бичигт Монголын талаас “Голомт” банкны ТУЗ-ийн дарга Л.Болдхуяг, Вьетнамын талаас “VIETCOM” банкны дэд захирал Нгуен Тхө Ха нар гарын үсэг зурлаа. Энэхүү баримт бичгийн үндсэн дээр бизнесийн үйл ажиллагааны төлбөр тооцоог Монгол, Вьетнам хоёр улсын банкаар шуудшижүүлэн хийснээр хоёр орны худалдааны эргэлт нэмэгдэж улам идэвхжих болно. БНСВУ-ын хамгийн том хоёр банктай хамтын ажиллагаатай болсноор нэгдүгээрт, гадаад төлбөр тооцоо найдвартай, түргэн шуурхай болохоос гадна аккредитивын үйлчилгээ хийж болно. Хоёрдугаарт, манай импортын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд худалдааны хөнгөлөлттэй зээлүүдэд хамрагдах том боломж нээгдэх юм.

Дараах нэг бэрхшээл нь Монгол, Вьетнам хоёр орны зах зээл, санхүү, эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, эрх зүйн талаархи мэдлэг, мэдээлэл хоёр талын бизнесийн хүрээнийхэнд тун хомс буюу бараг байхгүй.

Дүгнэлт

Монгол, Вьетнам хоёр орны 1990 оноос эдүгээг хүртлэх харилцааг нийтэд нь авч үзвэл улс төрийн хүрээнд зарчмын чанартай гол асуудлуудыг үндсэнд нь шийдвэрлэсэн гэж дүгнэх боловч худалдаа, эдийн засгийн харилцаа өнөөг хүртэл хүсч хүлээж байгаа түвшинд хүрээгүй хэвээр байна. Хоёр орны эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд улам таатай нөхцөл бүрдүүлэх, шийдлээ хүлээсэн эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх үүднээс цаашдын төлөв чиг хандлагатай холбогдуулан дараахи саналыг дэвшүүлж байна.

1. Монгол, Вьетнамын харилцаа, хамтын ажиллагааг нийгэм, эдийн засгийн өргөн хүрээнд, зах зээлийн харилцааны одоогийн нөхцөл байдал,

бодит хүчин зүйлтэй нь холбон, хөгжлийн шинэ шатанд гаргах зэрэг асуудлуудыг зангидсан бүтцийг бий болгох шаардлагатай байна. Монгол, Вьетнамын худалдаа, эдийн засаг, нийгмийн бүхий л хүрээнд эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэх, гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийн байдалд судлагаа, шинжилгээ хийх зорилго бүхий худалдаа, хамтын ажиллагааны нийгэмлэг байгуулах нь зүйтэй. Тус нийгэмлэг хоёр улсын түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааны хөгжлийн одоогийн байдалд нухацтай онош тавьж тодорхойлох, худалдаа, хөрөнгө оруулалт, бизнесийн орчинг хөгжүүлэх талаар хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр ажиллах, энэ зорилгоор судалгааны баг бүрдүүлэх, цаашид өөрийн үйл ажиллагааны талаар хоёр орны худалдаа, эдийн засаг, соёл, ШУТ-ийн холбогдох байгууллага болон бизнесийн хүрээнд танилцуулан сурталчилах, тус нийгэмлэгийн төлөөлөгчийн газар ажиллуулах зэрэг томоохон зорилтуудыг хэрэгжүүлэх болно. Мөн түүнчлэн, хоёр улсын засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг судлах, зарчмын дүгнэлт хийх, засгийн газар хоорондын комиссын шийдвэр, дүгнэлт, зөвлөмжүүдийн биелүүлэлтийн ажлын явцыг дэмжиж, сайн үр дүнд хүргэхийн төлөө нийгэмлэгийн зүгээс санаачлагатай ажиллана. Энэ нь өнөөгийн болон ирээдүйн Монгол, Вьетнам хоёр орны хооронд эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд тулгуурласан худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэн хөгжүүлэхэд үр өгөөжтэй байх болно.

2. 2006 оны 12-р сард Вьетнам улс Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүнээр элсэж, үндэсний хууль тогтоомж, дүрэм журмаа олон улсын жишигт нийцүүлэх, тарифын болон тарифын бус хориг саалдыг багасгах зэрэг арга хэмжээнүүд авч байгаа нь Монгол, Вьетнамын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд таатай нөхцлийг бүрдүүлж, хөгжлийн шинэ боломжийг нээж байна. Вьетнам улс ДХБ-д элссэнтэй холбогдуулж ДХБ-ын хүрээнд сонирхсон асуудлаар санал солилцож, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны талаар хамтран ажиллах, байр сууриа нэгтгэх, эрх зүйн шинэ орчин нөхцөлд гэрээ хэлэлцээрийг Монгол-Вьетнамын Засгийн газар хоорондын Комиссын хуралдаанаар шинэчлэн авч хэлэлцэх шаардлагатай.

3. Өнөөдөр хоёр орны хувьд дунд болон жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх нийтлэг хэрэгцээ сонирхол өсч байна. Энэ салбарт Вьетнам улс илүү туршлагатай. Хоёр тал энэ салбарт харилцан туршлага солилцож, хамтран ажиллах хөтөлбөр хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй. Олон салбарыг хамарсан дунд болон жижиг үйлдвэрлэлийг хамтран хөгжүүлэх, бизнес эрхлэгчдийг хооронд нь холбож өгөх тусгай механизм байснаар энэ ажил илүү их үр дүнтэй хэрэгжих боломжтой. Өнөөдөр Вьетнамын бизнесменүүд Монгол Улсад хамтарсан үйлдвэр байгуулах боломжийг судлах зорилгоор

удаа дараа Монголд айлчилсан хэдий ч шууд хөрөнгө оруулах асуудлаар хоёр тал одоо хүртэл дорвитой алхамд хүрч чадахгүй байна. Иймд, хамтарсан хөрөнгө оруулалт хийж, урт болон дунд хугацааны төсөл хэрэгжүүлэх, жижиг дунд үйлдвэр байгуулах хөгжлийн судалгаа хийх зорилгоор Монгол, Вьетнамын бизнес эрхлэгчдийн дугуй ширээний уулзалт, бизнес уулзалтыг хоёр талд зохион байгуулах ажлыг тогтмолжуулах шаардлагатай.

4. Хагас болон анхан шатны боловсруулалт хийсэн түүхий эд, материалаар эцсийн, эсхүл хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хамтарсан үйлдвэр байгуулах; хүнс, хөдөө аж ахуйн төрлийн бүтээгдэхүүн тарьж нөөцлөх, Монголын хөдөө аж ахуйд чийг усны нөөцийг хамгаалах технологи, үр тариа, тэжээлийн шинэ сорт нэвтрүүлэх, уламжлалт ардын эм, малын эм бэлдмэл хийх, ургамлын гаралтай эмийн үйлдвэрлэл, оёдол хатгамал, мод модон эдлэлийн зэрэг чиглэлээр жижиг үйлдвэрлэл байгуулан хамтран ажиллах боломж хоёр талд байгаа. Түүнчлэн, Монгол Улсын хилийн боомт, бүсийн тулгуур төвүүдэд Худалдаа, эдийн засгийн чөлөөт бүс, Үйлдвэр технологийн паркард Вьетнамын хөрөнгө оруулагчдыг идэвхтэй оролцуулж, томоохон хөрөнгө оруулалт хийх, хамтарсан үйлдвэр байгуулах боломжийг судлах; Вьетнамын бараа худалдаалах бөөний ба жижиглэн худалдааны хамтарсан төвүүд байгуулах; Вьетнамд Монголын жуулчны байгууллагын төлөөлөгчийн газар нээх, харилцан жуулчин солилцох, соёл гэгээрлийн, эрүүлийг хамгаалах, мал аж ахуй, газар тариалан зэрэг салбаруудад төлөөлөгчид солилцох, жижиг оврын усан цахилгаан станц шинээр барьж байгуулах, түүнд тоног төхөөрөмж, сэлбэг нийлүүлэх зэрэг чиглэлээр хамтран ажиллах нөөц боломж хоёр талд бий.

5. Монгол болон Вьетнамын бизнес эрхлэгчид өөрийн орны эрэлт хэрэгцээ, эдийн засгийн өсөлт, бүтэцтэй уялдуулан хамтарсан буюу зуун хувийн хөрөнгө оруулалттай компани байгуулан ажиллах өргөн боломж бий. Тухайлбал, ядуурлыг бууруулах үүднээс өрхийн аж ахуйг фермерийн аж ахуй болгон хөгжүүлэх, ашигт малтмалыг олборлох, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийх, чихэр, нарийн боовны үйлдвэрлэл, аялал жуулчлал зэрэг салбарт хамтран ажиллах, Вьетнамын үндэсний барааны дэлгүүрийг Монголд нээх, Вьетнамын экспортын барааны үзэсгэлэнг Монголд гаргаж үзүүлэх, Монголын онцлог бүтээгдэхүүн, тухайлбал, савхи, ноолуур, сүү, цагаан идээний болон уламжлалт эмийн түхий эд зэрэг бараа бүтээгдэхүүнийг Вьетнамд жил болгон зохион байгуулагддаг олон улсын үзэсгэлэнд оролцуулан суртачилах, Монголын бараа бүтээгдэхүүний дэлгүүрийг Ханой хотод нээх зэрэг боломжийг хайж хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Хоёр орны бизнесийн хүрээний харилцааг идэвхжүүлэн хөгжүүлэх зорилгоор янз бүрийн аж ахуйн нэгжүүдийн шууд харилцааг хөхиүлэн дэмжих,

Монгол, Вьетнамын бизнесменүүдийг харилцан өөрсдийн улсад ажиллуулах боломжийг хангах хэрэгтэй байна.

6. Монгол, Вьетнамын талууд аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах нь өнөөгийн үед нэн чухал асуудлын нэг болоод байна. Монгол, Вьетнам хоёр улсын хооронд харилцан аялал жуулчлалыг хөгжүүлэх нь хоёр орны эдийн засагт ч ихээхэн үр ашигтай юм. Монгол, Вьетнам хоёр улсын жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хоёр улсын уг салбарын бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол улсын иргэд Вьетнам орноор аялаж, тус улсын өнөөгийн хөгжил, ард түмний бүтээн байгуулалтын ололт амжилтыг харж, Вьетнамын түүх дурсгалын газрууд, үндэсний зан заншил, үзэсгэлэнт байгальтай танилцан, тус орны худалдаа, соёлын арга хэмжээнүүдэд оролцох бүрэн боломжтой. Түүнчлэн бусад улс орны жишгээр Вьетнам, Монгол хоёр улсын аялал жуулчлалын хамтарсан төвийг бий болгон, тус байгууллагын санхүүжилт өөрийн үйл ажиллагаанаас шууд хамааралттай байх зэргээр зохион байгуулж болно.

7. Хэдийгээр Монгол, Вьетнам хоёр орны сонин сэтгүүл, радио телевиз хоорондын хамтын ажиллагааны яриа хэлцэл хийгдээд удаж байгаа боловч Монгол, Вьетнам хоёр орны өнөөгийн хөгжил дэвшил, ололт амжилтын талаархи харилцан мэдээлэл бага хэвээр байна. Хоёр орны өнөөгийн хөгжлийн үйл явцын мэдээллийг интернет онлайн хэлбэрээр түргэн шуурхай дамжуулан хүргэх ажлыг улам эрчимжүүлэх шаардлага гарч байна. Үүнд Вьетнамд суралцаж буй монгол оюутнууд болон Монголд суралцаж буй вьетнам оюутнуудын идэвхтэй оролцоо нэн чухал.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. “20-р зууны Монгол улс, БНХАУ-ын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа”. Д.Батбаяр, 2002 он, УБ, 75-р х.
2. “Монгол-Вьетнам хоёр улсын найрамдал, хамтын ажиллагаа 60 жил” Б.Гантуяа, 2005 он, УБ, 118-р х.
3. Вьетнам Улсын Банк, Олон улсын хамтын ажиллагааны хэлтэс (2006), Ханой, “Вьетнамын Гадаад Худалдааны Банк болон Монгол Улсын банкууд хоорондын хамтын ажиллагааны тухай мэдээлэл” баримт бичиг
4. Bank for Foreign Trade of Vietnam (2005), Memorandum of business cooperation between Bank for Foreign Trade of Vietnam and Golomt Bank of Mongolia, Hanoi
5. “Vietnam Economic times” сэтгүүл 1998-2002